


БАТЛАВ. ӨМНӨГОВЬ АЙМГИЙН ЕРӨНХИЙ АРХИТЕКТОР / Ц. ЗОЛБОО /



(ӨМНӨГОВЬ АЙМАГ, ДАЛАНЗАДГАД СҮМ)

ЕГ Шифр: АТА-24/09

"ЦАГААНБУУЛАГ 8 ДУГААР БАГИЙН МОД ҮРЖҮҮЛЭГ ХОРООЛЛЫН БАРУУН ТАЛЫН ҮЕРИЙН ДАЛАНГ ЗАСВАРЛАЖ ТОХИЖУУЛАХ АЖИЛ"

(Ажлын зураг)

ЗАХИАЛАГЧ:

Өмнөговь аймгийн Даланзадгад сумын ЭДТГ-ын дарга

/А.Ганзүзэй/

БОЛОВСРУУЛСАН:

"АЮУТА" ХХК-ийн Захирал

/М.Бүянхушиг/

Архитектор

/Ш.Төгсжаргал/



ӨМНӨГОВЬ АЙМАГ
2024.0Н

БАЙРШЛЫН СХЕМ М1:5000



Тайлбар:


Өмнөговь аймгийн Даланзадгад сумын Цагаанбулаг 8 дугаар багийн нутаг дэвсгэрт орших үерийн шороон далангийн байгууламж нь хойноос урагшаа 320м орчим урттай, баруунаас зүүн тийш хамгийн өргөн хэсэгтээ 62м, хамгийн нарийн хэсэгтээ 1,8м орчим өргөнтэй, дунджаар 1-1.2м өндөр, 5600м.кв талбайг хамарсан, нийт шороон асгаасын хэмжээ 8400м.куб орчим /Зураг-1/. Тус даланг байгуулахдаа төлөвлөлт, зураг төсөлгүйгээр хийсэн тул эмх замбараагүй, төлөвлөлтгүй асгасан байдалтай байна. /Зураг-2/

Орчны газрын рельеф налууугийн нөлөөгөөр шороон далангийн баруун хэсэгт үерийн ус цуглах талбай үүссэн бөгөөд үерийн усаар урсаж цугласан лаг шавар хуримтлагдсан /Зураг-3/. Шаварлаг хөрсний дүтцээс үүдэн ус цуглах талбай нь ус их хэмжээний ус шингээх боломжгүй тул 0.5-1м орчим өнгөн хөрсийг зайлуулж, ул хөрсийг сийрэгжүүлэн, том хэмхдэст дайргаар дүүргэж хөрсний ус шингээх чадварыг нэмэгдүүлэх шаардлагатай.

Шороон далангийн хойд хэсгээр иргэдийн өмчлөлийн газрыг хүрээлэн төмөр блок хашаатай бөгөөд хашааны дагуу баруунаас зүүн тийш чиглэсэн автомашины шороон замтай /Зураг-4/. Зам дагуух газрын хонхор, тогтоол уснаас үүдэн автомашин чөлөөтэй зорчиход хүндрэл үүсч байгаа тул машин зам дагуу шороо асгаж өндөрлөн тээврийн хэрэгслийн чөлөөтэй зорчих боломжыг хангах шаардлагатай.

Мөн шороон далангийн зүүн хэсэгт барилгын хог, ойр орчмын хог хаягдал цугларч, зүүн талаар үерийн ус, лаг шавар цугласан нь ойр орчмын иргэд, явган хүн аюулгүй зорчих, дайран өнгөрөх боломжгүй болсон тул иргэдийн чөлөөтэй зорчих боломжийг хангах үүднээс шороон далан дагуу явган хүний зам тавих, далан руу гарах, далангаас буух бетон шатыг шаардлагатай хэсгүүдэд хийх хэрэгтэй.

ОДОО БАЙГАА ДАЛАНГИЙН БАЙГУУЛАЛТ М1:1200



ТАНИХ ТЭМДЭГ

- Иргэдийн өмчлөлийн газар
- Одоо байгаа шороон далан




Зураг.1 Шороон далангийн харагдах байдал



Зураг.2 Замбаагүй асгасан шороон асгаас



Зураг.3 Баруун талын ус цуглах талбай




Зураг.4 Шороон авто замын харагдах байдал



ЦАГААН БУЛАГ 8 ДУГААР БАГИЙН МОД ҮРЖҮҮЛЭГ ХОРООЛЛЫН ҮЕРИЙН ДАЛАНГ ЗАСВАРЛАЖ ТОХИЖУУЛАХ (ӨМНӨГОВЬ АЙМАГ, ДАЛАНЗАДГАД СУМ)					
ТАЙЛБАР БИЧИГ /1-Р ХЭСЭГ/					
Архитектор		А.Тэмүүлэн	ЕГ Шифр:	Масштаб:	Огноо:
Гүйцэтгэсэн		А.Тэмүүлэн	АТА-24/09	М1:1200	08.2024
Шалгасан		М.Буянхишиг	ТГ Шифр:	Зургийн дугаар:	Хуудас:
			ЕТ-01	ЕТ-01	05

ШИНЭ ТӨЛӨВЛӨЛТ М1:1250



ТАЙЛБАР:

Төлөвлөлт-1: Төлөвлөлтийн талбайд баруунаас зүүн тийш чиглэлтэй автозамын хийгдэхээр зураг төсөв хийгдэж батлагдсан байгаа бөгөөд уг төлөвлөлттэй уялдуулан трассын дагуу түр шороон зам хийхээр төлөвлөв. Автомашины сайжруулсан шороон зам 13м өргөн, 76м урт байхаар тооцов.

Төлөвлөлт-2: Сүүдрэвч бүхий тохижилт хийх зорилгоор шаталсан шороон тавцан хийхээр төлөвлөсөн бөгөөд 4 шатлалтай, шатлал бүрийн өндрийн зөрөө 0.5м байна.

Төлөвлөлт-3: Даланзадгад сумын үерийн ус зайлуулах нэгдсэн төлөвлөлт хийгдсэн байгаа бөгөөд нэгдсэн үерийн систем байгуулагдсаны дараа уг төлөвлөлтийн талбайн ус хураах талбай багасч уг шороон далан ус хаах үүрэггүй болно. Тиймээс уг шороон даланг усны бетон сувагчлалгүй хийхээр төлөвлөв. Шинээр төлөвлөгдөж буй шороон далан 332м урт, далангийн суурийн өргөн 7.1м, далангийн дээд өргөн 3.5м, далангийн өндөр 1.2м өндөр, далангийн хажуугийн налуулга 1:1 харьцаатай буюу 45градусын налуутай. Шинээр төлөвлөж буй даланг байгуулахдаа далангийн шороог 15см тутамд хийн доргиурт индүүгээр үчлэн нягтруулна. Шороон даланг үргэдийн өмчлөлийн газраас 11м зайтай байхаар төлөвлөсөн.

Төлөвлөлт-4: Шороон далан зураг төслийн дагуу байгуулсны дараа илүүдэл шороог ачиж зайлуулах ба шороо ачсан талбайг дульдозороор түрж газрын гадаргыг тэгшилнэ.



ТАНИХ ТЭМДЭГ

- Иргэдийн өмчлөлийн газар
- Шинээр төлөвлөж буй шороон далан -3200м³, 332м урт
- Зөөж зайлуулах илүүдэл асгаас шороо -2800м³
- Хаяалбар


<p>“АЮУТА” ХХК БАРИЛГЫН ЗУРАГ ТӨСӨЛ</p>	ЦАГААН БУЛАГ 8 ДУГААР БАГИЙН МОД ҮРЖҮҮЛЭГ ХОРООЛЛЫН ҮЕРИЙН ДАЛАНГ ЗАСВАРЛАЖ ТОХИЖУУЛАХ (ӨМНӨГОВЬ АЙМАГ, ДАЛАНЗАДГАД СУМ)					
	ШИНЭ ТӨЛӨВЛӨЛТ /1-Р ХЭСЭГ/					
	Архитектор		А.Тэмүүлэн	ЕГ Шифр:	Масштаб:	Огноо:
	Гүйцэтгэсэн		А.Тэмүүлэн	АТА-24/09	М1:1250	08.2024
Шалгасан		М.Буянхишиг	ТГ Шифр:	Зургийн дугаар:	Хуудас:	
				ЕТ-02	05	

ТӨЛӨВЛӨЖ БҮЙ ДАЛАНГИЙН БАЙГУУЛАЛТ М1:1200

ОГТЛОЛ А-А.
ДАЛАНГИЙН ХЭСЭГЛЭЛ М1:200



ЭКО ХАВТАН М1:25



Тайлбар:
Шинээр төлөвлөгдөж буй шороон далан 347м урт, далангийн суурийн өргөн 6м, далангийн дээд өргөн 3.5м, далангийн өндөр 1.2-1.4м өндөр, далангийн хажуугийн налуулга 1:1 харьцаатай, 45градусын налуутай. Шороон даланг иргэдийн өмчлөлийн газраас 11м зайтай байхаар төлөвлөсөн. Шинээр төлөвлөж буй даланг байгуулахдаа далангийн шороог 15см тутамд хийн доргиурт индүүгээр үечлэн нягтруулна.
Далангийн 2тал болон шаталсан шороон тавцангийн эхний 3 шатлалын налууг далангийн эко хавтангаар хашна. Хамгийн сүүлийн налуулга дагуу хавтан суурилуулахгүй. Хавтангийн бетоны марк М300-с багагүй, хавтангийн зузаан 8см-с багагүй байна.

ТАНИХ ТЭМДЭГ

- Иргэдийн өмчлөлийн газар
- Шинээр төлөвлөж буй шороон далан
- Хонхорыг шороогоор дүүргэж түрж тэгшилэх талбай
- Зөөж зайлуулах илүүдэл асгаас шороо
- Хаяалбар

АЖЛЫН ТОО ХЭМЖЭЭНИЙ ЖАГСААЛТ					
№	Материалын нэр	Өргөн	Урт	Өндөр	Нийт хэмжээ
1	Одоо байгаа шороон асгаас	-	-	1.5	8400м ³
2	Шороон далан	4.75	347	1.2	2350м ³
3	Шаталсан шороон тавцан	30	47	2	2500м ³
4	Түр шороон зам	13	44	1.2	500м ³
5	Хонхорыг дүүргэж түрж тэгшилэх шороо	35	160	0.1-0.5	2500м ³
6	Далангийн эко хавтан	1.4/0.5	748+156	-	1200м ²
	Ачиж зайлуулах илүүдэл шороо	13	76	1.2	500м ³

ЭРГЭЛТИЙН ЦЭГ

№	X	Y	Түвшин
1	453969.6719	4823578.4217	1472.25
2	453983.28	4823596.0649	1473.50
3	453996.5656	4823614.0949	1472.30
4	453942.7292	4823644.7037	1474.50
5	454049.8123	4823516.2625	1474.50
6	454170.0489	4823380.2425	1475.00


“АЮУТА” ХХК
БАРИЛГЫН ЗУРАГ ТӨСӨЛ

ЦАГААН БУЛАГ 8 ДУГААР БАГИЙН МОД ҮРЖҮҮЛЭГ ХОРООЛЛЫН ҮЕРИЙН ДАЛАНГ ЗАСВАРЛАЖ ТОХИЖУУЛАХ (ӨМНӨГОВЬ АЙМАГ, ДАЛАНЗАДГАД СУМ)


ДАЛАНГИЙН БАЙГУУЛАЛТ /1-Р ХЭСЭГ/

Архитектор		А.Тэмүүлэн	ЕГ Шифр:	Масштаб:	Огноо:
Гүйцэтгэсэн		А.Тэмүүлэн	ATA-24/09	М1:1250	08.2024
Шалгасан		М.Буянхишиг	ТГ Шифр:	Зургийн дугаар:	Хуудас:
			ET-03	ET-03	05


ОДОО БАЙГАА ШОРООН ЗАМ М1:750



ТӨЛӨВЛӨЖ БҮЙ ТҮР ШОРООН ЗАМ М1:750



ШОРООН ЗАМЫН ОГТЛОЛ Е-Е



Замын чиг сэргээх
Замд тохиромжтой хөрс хийж нягтруулах $\delta=200\text{мм}$
Газрын гадаргууг шороогоор тэгшилж нягтруулах


ОДОО ХАРАГДАХ БАЙДАЛ



ЗАМЫН ТЭНХЛЭГИЙН ЭРГЭЛТИЙН ЦЭГ

№	X	Y	Түвшин
1	453969.67	4823578.42	1473.25
2	453983.28	4823604.34	1474.50
3	453996.56	4823614.09	1472.35

ОГТЛОЛ Д-Д



ТАЙЛБАР:

Төлөвлөлт-1: Төлөвлөж буй талбайд баруунаас зүүн тийш чиглэх авто замын трасс, зураг төсөл батлагдсан байгаа тул уялдуулж трассын дагуу түр шороон зам төлөвлөв. Автомашины сайжруулсан шороон зам 13м өргөн, 43м урт байхаар тооцов.
Одоо байгаа автомашины шороон замыг ашиглахгүй тул шороогоор дүүргэж гадаргууг тэгшилнэ.

АЖЛЫН ТОО ХЭМЖЭЭНИЙ ЖАГСААЛТ

№	Материалын нэр	Хэмжих нэгж	Өргөн	Урт	Нийт хэмжээ
1	Замын чиг сэргээх	у/м	-	43	43
2	Замд тохиромжтой хөрс хийж нягтруулах $\delta=200\text{мм}$	м ³	15	43	100
3	Газрын гадаргууг шороогоор тэгшилж нягтруулах	м ³	15	43	480м ³



ЦАГААН БУЛАГ 8 ДУГААР БАГИЙН МОД ҮРЖҮҮЛЭГ ХОРООЛЛЫН ҮЕРИЙН ДАЛАНГ ЗАСВАРЛАЖ ТОХИЖУУЛАХ (ӨМНӨГОВЬ АЙМАГ, ДАЛАНЗАДГАД СУМ)

ТҮР ШОРООН ЗАМ

Архитектор		А.Тэмүүлэн	ЕГ Шифр: АТА-24/09	Масштаб: М1:500	Огноо: 08.2024
Гүйцэтгэсэн		А.Тэмүүлэн	ТГ Шифр:	Зургийн дугаар: ЕТ-05	Хуудас: 05
Шалгасан		М.Буянхишиг			